

**“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**
2021.06.25

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйц хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго-1. Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах ажлыг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж эхлүүлэх, батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулж төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах.							
1	Зорилт 1 -Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дархан-уул аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж гүйцэтгэлийг барилга байгууламжийн норм нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан баталгаажуулах.						
1.1	Барилга угсралт, авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээний 71 төсөл хөтөлбөр, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлэх.	24,4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 71 төсөл хөтөлбөрт хяналт хэрэгжүүлнэ	2020-2021 онд үргэлжлэн хэрэгжих 12 төсөл арга хэмжээ -2021 онд шинээр хэрэгжих 59 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлнэ.	2019-2020 онд шилжин хэрэгжсэн 16 төсөл арга хэмжээ, 2020 онд шинээр хэрэгжсэн 29,5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 161 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлж 1216 зөвлөмж даалгаврыг өгч биелэлтийг 97% иар хангуулан, 674 лабораторийн сорил шинжилгээ хийлгэн ил далд ажлын 1548 актыг баталгаажуулж, гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэж барилгын ажлын тоо хэмжээ гүйцэтгэлийг баталгаажуулсан. Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг ханган магадлашгүй ажлын зардлаас 86,7 сая	2021 онд Дархан-уул аймагт баригдах барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилтын 71 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техник хяналтыг хэрэгжүүлж барилга байгууламжийн болон норм нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан баталгаажуулж барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх.	2021 оны эхний хагас жилийн байдлаар 2020-2021 онд шилжсэн 26,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл арга хэмжээ, 2021 онд шинээр хэрэгжүүлж байгаа 5,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 26 төсөл, арга хэмжээ буюу нийт 38 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлж ажиллалаа. Техникийн хяналт хийх явцад 144 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч биелэлтийг 95% иас дээш хангуулан 294 ш лабораторийн сорил шинжилгээ хийлгэн ил далд ажлын акт 396 ийг баталгаажуулж, ажлын явцыг 1731 фото зургаар баримтжуулсан. Гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан 12 байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажууллаа. Мөн барилга угсралт, засвар шинэчлэлтийн 9 төсөл арга хэмжээ нь 100% дууссан тул байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.	95%

				төгрөгийг хэмнэсэн. Нийгмийн хариуцлагын хүрээнд 685,7 сая төгрөгийн өртөг бүхий 30 төсөл хөтөлбөрийг техник хяналтын зардалгүй гүйцэтгэсэн. 165 төсөл арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.		-2019-2021 онд шилжин хэрэгжсэн Бурхант хясаат ХХК-ийн гүйцэтгэсэн Дархан сумын 5 дугаар багийн 1-р хорооллын ИШС шинээр татах ажил" ын угсралтын ажил дууссан тул техникийн урьдчилсан комисс ажилласан. Одоо нөхөн сэргээлтийн ажил явагдаж байна. -2020-2021 онд шилжин хэрэгжсэн Биг рентал ХХК-ийн гүйцэтгэсэн "Сумын төвийн 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбосон авто замын гүүрэн гарцын эхний зэлжийн ажил" нь 100% дууссан тул техникийн комисс ажилласан.
1.2 БАРИЛГА УГСРАЛТ Зорилго 1.2 Барилга байгууламж шинээр барих, өргөтгөх шинэчлэн засварлах төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянаж баталгаажуулах.						
1.2.1	Нийт 33 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянаж баталгаажуулах.	10,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 33 төсөл, арга хэмжээ	2020-2021 онд үргэлжлэн хэрэгжих 5 төсөл арга хэмжээ -2021 онд шинээр хэрэгжих 28 төсөл арга хэмжээ	Нийт 91 төсөл арга хэмжээнд 2198 удаагийн захиалагчийн техникийн хяналт тавьж хэрэгжүүлж ажилласан ба энэ хугацаанд 486 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч биелэлтийг 90%-с дээш хангуулан 164 лабораторийн сорил шинжилгээ, тохирлын гэрчилгээ, 2690 фото зургаар баримтжуулан ил далд ажлын 359 актыг баталгаажуулан, гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүнгэн барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж гүйцэтгэлийг баталгаажуулсан. Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг ханган магадлашгүй ажлын зардлаас 13,2 сая төгрөгийг хэмнэсэн. Гүйцэтгэлийн дундаж хувь-97%	Барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилтын 33 төсөл/ -Зураг төслийг судалж дүн шинжилгээ хийх. -Ажил эхлэх объект тус бүр дээр хувийн хэрэг нээж өдөр тутмын мэдээллээр баяжуулан хөтлөх. -Үе шатны ажил бүрийг хэмжин шалгаж хүлээж авах, хэрэглэгдсэн материал, хийц бүтээцийн лабораторийн шинжилгээний сорил авч актаар баталгаажуулах. - Дараагийн үе шатны ажлын зөвшөөрлийг олгох. -Гүйцэтгэлийг батлагдсан төсвийн дагуу хянаж санхүүжүүлэх.	Барилга угсралт, засвар шинэчлэлт тохижилтын 18 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлж ажилласан ба 28 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч биелэлтийг 95%-иас дээш хангуулан 23 лабораторийн сорил шинжилгээ, тохирлын гэрчилгээ хийлгэсэн ба төсөл арга хэмжээний ажлын явцыг 250 фото зургаар баримтжуулж үе шатны 42 ажлыг ил далд актаар баталгаажуулсан. 3 байгууллагын гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүнгэн барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж санхүүжилтийг хянан баталгаажуулсан. Шийдвэрлэсэн асуудал: 1.Нийтийн эзэмшлийн орон сууцны их засварын ажил /Дархан-Уул, Дархан сум, 4,5,8,9, Өргөө баг /Багц-1-Вилла Бридж ХХК; Байрнуудын хананд өлгөсөн байгууллагуудын хаягийг буулгасан.

1.3 ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ-ДУЛААН БОЛОН УСАН ХАНГАМЖ

Зорилго 1.3 Инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.

1.3.1	Нийт 7 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.	2,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээ	-2020-2021 онд үргэлжлэн хэрэгжих төсөл арга хэмжээ 2 -2021 онд шинээр хэрэгжих төсөл арга хэмжээ 5	2020 онд нийт 23 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлж 154 зөвлөмж, даалгаврыг өгч биелэлтийг 98%-иас дээш хангуулан, 175 лабораторийн сорил шинжилгээ хийлгэн ил далд ажлын 615 актыг баталгаажуулж, гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэж 31 гүйцэтгэлийг баталгаажуулсан. 2020-2021 онд шилжин хэрэгжих 2 төсөл арга хэмжээ. Байнгын ашиглалтад оруулсан 21 төсөл арга хэмжээ. Үүрэг даалгаврын биелэлт 98%	Инженерийн шугам сүлжээний 7 төсөл/-Зураг төслийг судалж дүн шинжилгээ хийх. -Ажил эхлэх объект тус бүр дээр хувийн хэрэг нээж өдөр тутмын мэдээллээр баяжуулан хөтлөх. -Үе шатны ажил бүрийг хэмжин шалгаж хүлээж авах, хэрэглэгдсэн материал, хийц бүтээцийн лабораторийн шинжилгээний сорил авч актаар баталгаажуулах. - Дараагийн үе шатны ажлын зөвшөөрлийг олгох. -Гүйцэтгэлийг батлагдсан төсвийн дагуу хянаж санхүүжүүлэх.	2020-2021 онд УТХО-ын шилжсэн ИШС-3 барилга угсралтын 2 төсөл арга хэмжээ, ОНХС 2 төсөл арга хэмжээнд өдөр тутмын болон үе шатны захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэн ажилласан ба 12 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч, биелэлтийг 96%-иас дээш хангуулан ашиглаж буй материалын дээжээс 21 лабораторийн сорил шинжилгээ авч, итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн. Төсөл, арга хэмжээний ажлын явцыг 160 ш фото зургаар баримтжуулан, үе шатны 92 ажлыг ил далд ажлын актаар баталгаажуулсан. 2 байгууллагын гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэн барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж санхүүжилтийг хянан баталгаажуулсан. Шийдвэрлэсэн асуудал- 1."Бурхант хясаат" ХХК-ийн гүйцэтгэсэн "Дархан сумын 5-дугаар багийн гэр хорооллын ИШС-ний ажил"-д нөхөн сэргээлтийн ажлыг хэрхэн хийх талаар захиалагч, зураг зохиогч, гүйцэтгэгч байгууллагуудын техникийн зөвлөгөөн зохион байгуулж тодорхой шийдэл гаргасан. Батлагдсан зураг төсөлд эко хавтангаар бохир усны шугам трассын дагуу бэхлэгээ хийхээр тусгагдсан байсныг 2020 оны 6-р сарын 2-ны өдөр аймгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын хурлаар зургийн байгууллага, гүйцэтгэгчтэй хамтран хуралдаж уулын ус ихээр хуралддаг 4 хэсэгт 1700мкв газарт далангийн материал дэвсгэж нягтруулга хийхээр болсон. 2."Өгөөмөр баян булаг" ХХК-ийн	96%
-------	---	--	--	--	--	--	-----

						Тосгон чиглэлийн гадна дулааны шугам угсралтын ажлын зураг төсөлд төмөр замын байгуулалтад зөвшилцөөгүй байсныг 2020 оны 5-р сарын 31-ний өдөр захиалагч, зургийн автор, гүйцэтгэгч нартай хамтран техникийн зөвлөгөөнөөр асуудлуудыг шийдвэрлэсэн.	
--	--	--	--	--	--	---	--

1.4 АВТО ЗАМ, ГАРЦ ЗОГСООЛ

Зорилго 1.4 Авто зам, зогсоол шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.

1.4.1	Нийт 23 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.	7,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл арга хэмжээ	-2020-2021 онд үргэлжлэн хэрэгжих 3 төсөл арга хэмжээ 2021 онд шинээр хэрэгжих 20 төсөл арга хэмжээ	Нийт 50 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт тавьж 576 зөвлөмж, даалгаврыг өгч биелэлтийг 97%-с дээш хангуулан, 335 лабораторийн сорил шинжилгээ хийлгэн ил далд ажлын акт 574 баталгаажуулж, гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэж гүйцэтгэлийг баталгаажуулсан. Байнгын ашиглалтад оруулсан 47 төсөл, арга хэмжээ 2020-2021 онд шилжин хэрэгжих 3 төсөл арга хэмжээ. Үүрэг даалгаврын биелэлт 97%	/Авто зам, замын байгууламжийн 23 төсөл/-Зураг төслийг судалж дүн шинжилгээ хийх. -Ажил эхлэх объект тус бүр дээр хувийн хэрэг нээж өдөр тутмын мэдээллээр баяжуулан хөтлөх. -Үе шатны ажил бүрийг хэмжин шалгаж хүлээж авах, хэрэглэгдсэн материал, хийц бүтээцийн лабораторийн шинжилгээний сорил авч актаар баталгаажуулах. - Дараагийн үе шатны ажлын зөвшөөрлийг олгох. -Гүйцэтгэлийг батлагдсан төсвийн дагуу хянаж санхүүжүүлэх.	Эхний хагас жилийн байдлаар авто зам, замын байгууламжийн 14 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан ба 51 удаа зөвлөмж, даалгаврыг өгсөн ба биелэлтийг 97% иас дээш хангуулан 726 цэгт түвшин шалгаж 143 цэгт нягт үзэж, төсөл арга хэмжээний ажлыг явцыг 1098 ш фото зургаар баримтжуулсан ба ашиглаж буй материалын дээжээс 224 лабораторийн сорил шинжилгээ авч, итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн. Үе шатны ажлуудад хэмжилт шалгалт хийж 171ш актыг баталгаажуулсан. 11 объектийн гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэн барилгын ажлын ажлын тоо хэмжээг тулган шалгаж, гүйцэтгэлийн санхүүжилтийг баталгаажуулсан.	97%
-------	---	--	--	--	---	--	-----

1.5 ГЭРЭЛТҮҮЛЭГ, ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Зорилго 1.4 Цахилгаан хангамж, гэрэлтүүлэгийн ажлыг шинээр угсрах, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.

1.5.1	Нийт 5 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын	1,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл арга хэмжээ	-2020-2021 онд үргэлжлэн хэрэгжих 1 төсөл арга хэмжээ -2021 онд шинээр хэрэгжүүлэх 4 төсөл арга хэмжээ	2019-2020 онд шилжсэн 1 төсөл арга хэмжээ, 2020 онд шинээр нийт 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий 9 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлж 18 зөвлөмж,	Цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн 5 төсөл, арга хэмжээ/-Зураг төслийг судалж дүн шинжилгээ хийх. -Ажил эхлэх объект тус бүр дээр хувийн хэрэг нээж өдөр тутмын мэдээллээр баяжуулан хөтлөх.	2020-2021 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа 1 төсөл арга хэмжээ, 2021 онд шинээр гэрээ байгуулан хэрэгжиж байгаа 386,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ болон хамтарсан техник хяналтыг хэрэгжүүлж 30 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч, биелэлтийг 95% иас дээш хангуулан 18 лабораторийн сорил	95%
-------	---	---	---	---	---	---	-----

202

гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах	үр			даалгаврыг өгч биелэлтийг 98%-иас дээш хангуулж 20 лабораторийн сорил шинжилгээ хийлгэн ил далд ажлын 40 актыг баталгаажуулж, гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэж гүйцэтгэлийг баталгаажуулсан. Байнгын ашиглалтад оруулсан 9 төсөл арга хэмжээ. Шилжин хэрэгжих 1 төсөл арга хэмжээ Үүрэг даалгаврын биелэлт 98%	-Үе шатны ажил бүрийг хэмжин шалгаж хүлээж авах, хэрэглэгдсэн материал, хийц бүтээцийн лабораторийн шинжилгээний сорил авч актаар баталгаажуулах. - Дараагийн үе шатны ажлын зөвшөөрлийг олгох. -Гүйцэтгэлийг батлагдсан төсвийн дагуу хянаж санхүүжүүлэх.	шинжилгээ авч, итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн. Ажлын хэцэг 124ш фото зургаар баримт хуулан, үе шатны ажлуудад хэмжилт шалгалт хийж 58ш актыг баталгаажуулсан. Гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэн барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж 3 гүйцэтгэлийг баталгаажуулсан. Шийдвэрлэсэн асуудал: Дархан сумын 4, 5, 8, 9, Өргөө багийн нийтийн эзэмшлийн орон сууцны их засвар, замын гэрэлтүүлэгийн ажлын хүрээнд байрны фасадны гэрэлтүүлэг давхардсан байсныг 2020 оны 4-р сарын 29-ны өдөр захиалагч, зураг зохиогч, гүйцэтгэгч нарын төлөөлөл нартай объект дээр нь хуралдаж асуудлыг шийдвэрлэсэн. Шинэ хуучин Дарханыг холбосон авто замаас 27-р байрны дэргэдэх 4-н замын уулзвар хүртэлх авто замын трассын дагуух 0,4, 6 кВ-ын ЦДАШ-ын 8 зөрлөг хүчитгэх байсныг 2021 оны 05 сарын 09-ны өдөр захиалагч, зураг зохиогч, гүйцэтгэгчтэй нартай газар дээр нь хуралдаж ЦДАШ-ын 9-н зөрлөгт нэмж хүчитгэл хийх шийдвэр гаргуулсан. Дархан сумын "Миний монгол" цэцэрлэгт хүрээлэнгийн "Хүүхэд залуучуудын соёл амралтын цогцолборын тоглоом, алсыг харагч, аянга хамгаалалт" -ын угсралт нь цахилгаан тоног төхөөрөмжийн угсралтын норм дүрэм, зургийн дагуу угсраагүй аянга хүлээн авагчийн өндрийн хамгаалах хүрээнд объект нь багтахгүй байсныг буулгаж зургийн дагуу хүлээн авагчийг өндөрлөж хамгаалах бүсэд нь оруулан дахин угсруулах арга хэмжээ авч ажилласан.
---	----	--	--	--	---	--

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төсөл Зорилго 1.6 Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төслийн ажилд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлэх.

1.6.1	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төслийн ажилд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах.	Гадаад эх үүсвэр	2017-2021 онд үргэлжлэн хэрэгжинэ.	Төслийн А1 багцын хүрээнд Пфайфер-ЭМИТ түншлэлийн барилга угсралтын ажилд 2020 оны жилийн эцсийн байдлаар манай байгууллага нь 53 удаагийн хамтарсан техник хяналт, 475 удаагийн бие даасан техникийн хяналт гүйцэтгэж барилгын ажлын явцад батлагдсан график төлөвлөгөөний дагуу зураг төсөл, норм дүрэм, стандартын шаардлагыг хэрэгжүүлэн хэмжилт шалгалтыг хийж, зөвлөмж үүрэг даалгавар өгч гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг авч ажиллалаа. МОН-3244/3245 төслийн хүрээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар Пфайфер-ЭМИТ түншлэлийн гүйцэтгэж байгаа 32 барилга байгууламжийн угсралтын ажилд 56 удаа зөвлөмж даалгаварийг өгч, биелэлтийг хангуулан, 93 лабораторийн сорил шинжилгээ хийлгэн ил далд ажлын 196 актыг баталгаажуулж 893ш фото зургаар баримтжуулан, барилгын ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг баталгаажууллаа. Нийт төслийн ажлын гүйцэтгэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 68% тай, хоцрогдол 32%тай байна.	Төслийн үр дүнд орчин үеийн Үйлдвэрлэлийн бүтээмж өндөртэй, эрчим хүчний хэмнэлттэй цэвэрлэх процесс болох биосфильм технологийг (идэвхжүүлсэн лаг) ашиглах шинэ цэвэрлэх байгууламж орох бөгөөд нийт барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг шинээр барьж суурилуулж тоноглоно. 2021 онд гэрээгээр 100% дуусгана.	-Төслийн А1 багцын хүрээнд Пфайфер-ЭМИТ түншлэлийн барилга угсралтын ажилд 2021 оны 2-р улиралд нийт 43 удаа захиалагчийн техник хяналт хэрэгжүүлж, барилгын угсралтын ажлын тэмдэглэлд тогтмол тэмдэглэл хийж, нийт 23 удаа зөвлөмж шаардлага хүргүүлсэн. Хамтарсан техник хяналтыг "Дархан-Ус суваг" ХХК, Дархан ТУН-тай 20 удаа хийсэн. -Төслийн А2 багцын хүрээнд Байгууламж ХХК-ийн барилга угсралтын ажилд Ковид-19 цар тахлын улмаас 2 хоногт 1 удаа нийт 39 удаа захиалагчийн техник хяналт хэрэгжүүлж өдөр тутам зөвлөмж шаардлага хүргүүлсэн. Хамтарсан техник хяналтыг "Дархан-Ус суваг" ХХК, Дархан ТУН-тай 15 удаа хийсэн. Ашиглаж буй материалын дээжээс 8 лабораторийн сорил шинжилгээ авч, итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн. Төсөл, арга хэмжээний ажлын явцыг 99 ш фото зургаар баримтжуулан, үе шатны 33 ажлыг ил далд ажлын актаар баталгаажуулсан. 1 объектын гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэн барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж санхүүжилтийг хянан баталгаажуулсан. Шийдвэрлэсэн асуудал: Аэротенкийн барилгын технологийн алдаа гаргасан хэсэгт төслийн дэмжих хурлаас гарсан шийдвэрийн дагуу зөвлөх инженерийг талбай дээр ажиллуулан үл нийцэл үүссэн хэсгийн цутгалтыг гүйцэтгэх технологийн аргачлалыг боловсруулж дүгнэлт гаргуулан, цутгалтын ажлыг хяналтын дор гүйцэтгэсэн.	90%
-------	---	------------------	------------------------------------	--	--	--	-----

40

1.7 Гүйцэтгэлийг төсөв хянан баталгаажуулах

Барилга байгууламж шинээр барих, өргөтгөх шинэчлэн засварлах төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын тоо хэмжээ, төсөв гүйцэтгэлийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган хянан баталгаажуулах зорилтын хүрээнд

1.7.1	Барилга угсралт, авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээний 71 төсөл, арган хэмжээнд төсвийн хяналт хийж баталгаажуулах.	24.4 тэрбум төгрөг	24.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 71 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн төсөвт хяналт хийж баталгаажуулах.	2019-2020 онд хийлжин хэрэгжсэн 16 төсөл арга хэмжээ, 2020 онд шинээр хэрэгжсэн 29,5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 161 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлж гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэж барилгын ажлын тоо хэмжээ, төсвийг шалгаж гүйцэтгэлийг баталгаажуулсан.	2021 онд хэрэгжих барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилтын 71 төсөл арга хэмжээний төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан баталгаажуулж санхүүжилтийн хүсэлт явуулах.	2020 оны төсөл арга хэмжээнээс 4 байгууллагын 1,605.9 сая төгрөг, ОНХС-аар 2 байгууллагын 658,5 сая төгрөг, ОНХО-аар 6 байгууллагын 168,3 сая төгрөгийн гүйцэтгэлийн төсвийг хянан баталгаажуулж санхүүжилтийн хүсэлтийг аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.	100%
-------	--	--------------------	--	---	---	---	------

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 2- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх.

2.1 Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах, газрын сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулж ажилчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх.

2.1.1	Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах.		Хамт олны багаар ажиллах болон мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх.	Байгууллагын удирдлага нь ажилтнуудыг Төрийн банкны 4 давхарт 3 өрөө түрээслэн ажлын байраар хангаж ИТА, албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, бичиг хэрэг, автомашин, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хоолны мөнгө, унааны зардал, улирал бүр үр дүнгийн урамшуулал, сар бүр үр чадварын нэмэгдэл зэргийг олгож ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. Хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах, өөрчлөлтийг хүлээж авах, оновчтой шийдвэр гаргах, үр чадвараа дээшлүүлэхэд 12 албан хаагчдыг хамруулсан.	Хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах, өөрчлөлтийг хүлээж авах, оновчтой шийдвэр гаргах, мэргэжлийн үр чадвартай инженер техникийн ажилтан, албан хаагчид бүхий хамт олныг бүрдүүлсэн байна.	Байгууллагын ИТА албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байр, тоног төхөөрөмж, бичиг хэрэг, автомашин, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хоол унааны мөнгө, үр чадварын нэмэгдэл зэргийг олгож ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. 2021 оны батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан эхний хагас жилийн байдлаар гэрээгээр 3 инженер нэмж ажилд аван нийт 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явууллаа.	100%
-------	--	--	---	--	--	---	------

88

				Газрын Дарга нь төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, зохиох ур чадвар, үр дүнгийн урамшууллыг олгосон. 2020 онд батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулсан. Хүний нөөц, удирдах ажилтны судалгааг аймгийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.			
2.1.2	Сургалтын хэрэгцээг тодорхойлж төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдах, сургалт зохион байгуулах.	Сургалтын зардал	Газрын сургалтын төлөвлөгөөний дагуу инженер техникийн ажилтан, албан хаагчдыг сургалтанд хамруулж мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх.	2020 онд цар тахлын улмаас Улаанбаатар хотод явагдах байсан хуваарьт сургалтууд цуцлагдсан тул сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдаж чадаагүй ч ИТА, албан хаагчид Ерөнхий инженерийн удирдан зохион байгуулсан "БНБД"-ийн сургалт болон, нягтлан бодогчийн зохион байгуулсан Цалин хөлс хэрхэн бодогддог тухай" сургалтуудад тус тус хамрагдаж өөрийн мэдлэг ур чадвараар дээшлүүлсэн.	Сургалтын төлөвлөгөөний дагуу инженер техникийн ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн сургалтанд хамруулсан байна.	2021 оны байгууллагын батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу Барилгын хяналтын инженер Б.Анхбаяр, Сантехникийн хяналтын инженер Б.Гантуяа нар нь Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулж буй "Мэргэшсэн инженер" ийн багц цагийн сургалтад цахимаар хамрагдсан. Бичиг хэргийн ажилтан А.Нарангарав нь Архивын ерөнхий газраас зохион байгуулсан "Архив-албан хэрэг хөтлөлт"-ийн сургалтад цахимаар хамрагдсан. Авто замын инженер Д.Аюурзана нь Үндэсний Дата төвөөс зохион байгуулсан Вэб админ, вэб хуудас хөгжүүлэх сургалтад хамрагдсан. Мөн Авто замын мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдаж байна. Мөн ИТА, албан хаагчид нь Ерөнхий инженерийн зохион байгуулсан "Нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн талаар танилцуулга хичээл болон БНБД ийн сургалтад цахимаар хамрагдаж мэдлэг, мэргэшил ур чадвараа дээшлүүлсэн.	100%

2.2 Мэдээ тайлан гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

2.2.1	Мэдээ тайлан гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх	Төсөв шаардагдахгүй	Барилга угсралтын явцын мэдээ тайланг тогтмол гаргаж газрын удирдлага болон холбогдох байгууллагуудад хүргүүлэх. Мөн төсөл арга хэмжээ бүрээр мэдээллийн сан бүрдүүлэх.	Газрын хэмжээнд 2020 онд 177 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлэн ажилласан ба аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хуралд долоо хоног бүр оролцон улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилгын ажлын явцын талаар мэдээ тайланг хэлэлцэж яаралтай шийдвэрлэх асуудлыг шийдвэрлэн үүрэг даалгавар авч биелэлтийг хангуулж ажиллалаа. Долоо хоног бүрийн барилгын ажлын явцын мэдээг цахимаар аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлсэн. Мөн 3244/3245 төслийн сарын ажлын төлөвлөгөө, тайланг Дархан төслийн удирдах нэгжид хүргүүлээ. Тус газрын хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 3 удирдах албан тушаалтан нь хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж цахим мэдээллийн санд оруулсан.	Барилга угсралтын явцын мэдээ тайланг тогтмол гаргаж газрын удирдлага болон холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. Төсөл арга хэмжээ бүрээр мэдээллийн санг бүрдүүлж, өдөр тутмын мэдээллээр баяжуулж хувийн хэрэг үүсгэсэн байна.	2021 оны эхний хагас жилийн байдлаас нийт 38 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлэн ажилласан ба аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хуралд оролцон барилгын ажлын явцын талаар мэдээ тайланг хэлэлцэж шийдвэрлэх асуудлыг шийдвэрлэн үүрэг даалгавар авч биелэлтийг хангуулж ажилласан. Мөн 3244/3245 төслийн сарын ажлын төлөвлөгөө, тайланг Дархан төслийн удирдах нэгжид сар бүр хугацаанд нь хүргүүлж ажилласан. Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулсан ба эхний хагас жилийн худалдан авах ажиллагааны тайланг ОНӨГ-т хүргүүлсэн. Мөн 2020 оны гүйцэтгэлийн тайлан, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн. 2020 оны байгууллагын жилийн эцсийн тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид болон аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Санхүүгийн ил тод байдлын мэдээг shilendans.gov.mn сайтад сар бүр гаргаж олон нийтэд мэдээлсэн. Мөн 2020 санхүүгийн тайланг гарган аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагын хэмжээнд 318ш архивын хадгаламжийн нэгж хадгалагдаж байгаа ба 2020 оны жилийн эцсийн мэдээг аймгийн Архивын тасагт хүргүүлсэн. 2020 онд хэрэгжсэн төсөл бүр дээр нийт 112 ш архивын баримтыг үдэж цэгцлэн байгууллагын архивын хадгаламжид шилжүүлээ.	100%
-------	---	---------------------	---	---	--	--	------

18

				Барилга угсралт, засвар шинэчлэлт, өргөтгөлийн 17 төсөл арга хэмжээ бүрээр объектын тайлан гаргаж газрын мэдээллийн санг бүрдүүлж ажилласан ба тайланг хагас болон бүтэн жилээр аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлээ.			
2.2.2	Холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах	Төсөв шаардагдахгүй.	Аймаг орон нутгийн удирдлага болон холбогдох байгууллагуудыг барилга угсралтын төсөл хөтөлбөр, арга хэмжээний явцын тухай мэдээллээр хангаж ажиллах.	Газрын удирдлага болон аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хуралд оролцон барилгын ажлын явцын мэдээ тайлангаар тогтмол хангаж ажилласан. 2020 онд байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 372 албан бичиг хүлээн авч, 634 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа. Хариутай албан бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэн биелэлтэнд нь хяналт тавин үйл ажиллагаа явуулсан. Мөн Дарханы мэдээ цахим хуудастай хамтран ажиллаж улсын болон орон нутгийн төсвөөр хэрэгжиж буй томоохон төсөл арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлсэн.	Аймаг орон нутгийн удирдлага болон холбогдох байгууллагуудыг барилга угсралтын төсөл хөтөлбөр, арга хэмжээний явцын тухай мэдээллээр хангаж ажилласан байна.	Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хуралд долоо хоног бүр оролцон барилгын угсралтын ажлын явцын талаар мэдээ тайланг хэлэлцэж яаралтай шийдвэрлэх асуудлыг шийдвэрлэн үүрэг даалгавар авч биелэлтийг хангуулж ажилласан. Мөн барилгын ажлын явцын мэдээ тайланг цахимаар Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, Мэдээлэл технологийн албанд хүргүүлсэн. Дарханы мэдээ цахим хуудастай хамтран ажиллаж улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй томоохон төсөл арга хэмжээний явцын талаар олон нийтэд мэдээлсэн. 2021 онд байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 131 албан бичиг хүлээн авч 129 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа. Хариутай албан бичиг, өргөдлийг цаг хугацаанд нь шийдвэрлэн биелэлтэнд нь хяналт тавин үйл ажиллагаа явууллаа.	100%
2.3 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах.							
2.3.1	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах.	Үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлнэ.	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах.	Дарханы мэдээ цахим хуудсаар дамжуулан улсын болон орон нутгийн төсвийн томоохон хөрөнгө оруулалт бүхий барилга	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулсан байна.	Байгууллагын da.barilga.gov.mn вэб хуудас, Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар цахим хуудас болон Дарханы мэдээ цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын	100%

28

			"Дархан-Хот байгуулалт барилга захиалагчийн газар" цахим хуудсаар дамжуулан олон нийтэд барилгын ажлын явцын талаар мэдээ мэдээлэл тавих.	байгууламжийн явцын тухай мэдээллийг олон нийтэд түүлж ажилласан. Дархан-уул аймгаас сонгогдон ажиллаж буй УИХ-ын гишүүд, аймаг орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангасан. 2020 онд ашиглалтад орсон зарим томоохон төсөл арга хэмжээний нээлт болон шав тавих ёслолыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ДОНЗ, болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулж олон нийтэд сурталчлан таниулсан.		ажлын явц, фото зургийг дэлгэрэнгүй тайлбартайгаар олон нийтэд хүргүүлэн ажиллалаа. Байгуулагын цахим хуудаст байршуулсан мэдээг давхардсан тоогоор 18789 хүн харсан ба 894 хүн дэмжин, 911 хүн дагасан үзүүлэлттэй байна.	
2.4 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.							
2.4.1	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.		Холбогдох хууль, тогтоол, дүрэм, журмыг баримтлан Газрын дарга нь тушаал шийдвэр гаргах ба ажилчид үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллах	2020 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Барилга захиалагчийн дүрэм, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх журам, ЗГ-ын тогтоол журам, заавар, зөвлөмж, Дархан-уул аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын захирамж, шийдвэр, ДХББЗГ ОНӨААТҮГ дүрэм,	Холбогдох хууль, тогтоол, тушаал шийдвэр, дүрэм журмыг мөрдлөгө болгон ажилласан байна.	2021 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Барилга захиалагчийн дүрэм, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх журам, ЗГ-ын тогтоол журам, заавар, зөвлөмж, Дархан-уул аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын захирамж, шийдвэр, "ДХББЗГ" ОНӨААТҮГ дүрэм, Байгууллагын дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ, Газрын даргын тушаал шийдвэр зэрэг хууль тогтоомж тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Хууль тогтоомжийг үндэслэл болгон Даргын А тушаал 40 ш, Б тушаал 24	100%

28

				Байгууллагын дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ, Газрын зэргийн тушаал шийдвэр зэрэг хууль тогтоомж тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.		ш гарган мөрдөж ажилласан.	
2.5 Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах.							
2.5.1	Төсвийн төлөвлөгөө боловсруулж батлуулан ажиллагаа явуулах.	220.0 сая төгрөг	2021 оны санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллагаа явуулах.	2020 оны батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаа явуулсан. Худалдан авах төлөвлөгөөний дагуу 56,9 сая төгрөг, цалингийн зардалд 132,5 сая төгрөг, бусад зардалд 22,5 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Нийт үйл ажиллагааны зардалд 211,9 сая төгрөг зарцуулсан.	2021 оны санхүүгийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явагдсан байна.	2021 оны батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаа явуулсан. Худалдан авах төлөвлөгөөний дагуу 12,2 сая төгрөг, цалингийн зардалд 42,7 сая төгрөг, бусад зардалд 43,8 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Нийт үйл ажиллагааны зардалд 98,7 сая төгрөг зарцуулсан.	100%
2.5.2	Газрын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж аудитын дүгнэлтээр баталгаажуулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх	500,000 төгрөг	Санхүүгийн тайланг цаг нь гаргаж баталгаажуулах	Санхүүгийн тайлан улирлаар болон жилээр гарган Далай ван аудитын байгууллагаар баталгаажуулан холбогдох газруудад цаг хугацаанд нь хүргүүлсэн.	Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргаж аудитаар баталгаажуулан холбогдох газруудад хүргүүлэх.	2020 оны жилийн эцсийн тайлан ЦЭСБ аудит ХХК-аар баталгаажуулан төрийн аудитын газраас зөрчилгүй санал дүгнэлтэй. Холбогдох газруудад мэдээ тайланг цаг хугацаанд нь хүргүүлсэн.	100%
2.5.3	Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулах.		Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулах.	2020 онд байгууллагын үйл ажиллагаанд 219,8 сая төгрөгийг зарцуулсан. Нийт борлуулалт орлого 100%-тар бүрдүүлсэн, авлагыг 25 сая төгрөгөөр бууруулсан. Татварын өрийг бүрэн барагдуулсан. Аймгийн төсөвт цэвэр ашгийн 25% иар ноогдол ашиг төлсөн.	Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулан ажилласан байна.	Ковид-19 цар тахлын үед хөл хориотой байгаатай холбогдон гүйцэтгэгч байгууллагын ажил удааширч борлуулалтын орлого 20%-иар бүрдүүлсэн. 13,7 сая төгрөгийн өрийг барагдуулан, аймгийн төсөвт 8,0 сая төгрөгийн ноогдол ашиг төвлөрүүлсэн.	100%
2.5.4	Бараа материалын		Тооллого зохион байгуулах	2020 онд хагас бүтэн жилээр үндсэн	Хагас бүтэн жилээр тооллого зохион	Газрын 2021 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөний дагуу бараа	

	болон үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах			хөрөнгийн тооллого зохион байгуулсан. Тооллогоор 7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсон. Байгууллагын Тоёота сай автомашиныг аймгийн ИТХ-ын тогтоолоор Мэдээлэл технологийн албанд хүлээлгэн өгч данснаас хассан. Шинээр 8,6 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авсан. Үндсэн хөрөнгийг эзэмшигч бүрт карт нээн гарын үсгээр баталгаажуулсан.	байгуулагдсан байна.	материал, шатахууны талон худалдан авч анхан шатны баримтыг үндэслэн оролгод аван шаардах хуудас болон шатахуун олгох хуудсыг үндэслэн ажилтнуудад олгосон. 2021 оны 05 дугаар сарын 18 ны өдрийн Дархан-Уул аймгийн орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу манай байгууллага дээр 2021 оны 06 дугаар сарын 07 нд аймгаас комисс томилогдон ирж тооллого зохион байгуулсан. Тооллогоор дутсан, илүүдсэн хөрөнгө байхгүй. Нийт 73,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсон. Мөн Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 31 ний өдрийн 01-А/163 тоот захирамжаар 7 төрлийн 4,163,632 төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсны дагуу байгууллагын өмч хамгаалах зөвлөл хуралдан үндсэн хөрөнгийг актлан тайланг ОНӨГ-т хүргүүлсэн. Шатахуун худалдан авах тендерийг газрын Даргын 2021-01-15 ны өдрийн А/02 тоот тушаалын дагуу зохион байгуулсан ба 2 оролцогч оролцож Сод монгол групп шалгарч 2021 оны 3 р сарын 10 нд 11,672,000 төгрөгийн "Шатахуун худалдан авах тендерийн гэрээ"-г байгуулсан.	100%
2.6 Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төсөл засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдлийн удирдлагаар хангах.							
2.6.1	Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах		Ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын үр дүнг үнэлэх.	Гэрээгээр ажиллаж байгаа болон үндсэн ажилтнаар ажиллаж байгаа бүх албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж төлөвлөгөө, тайлангийн биелэлтийг үндэслэн үр чадвар, үр дүнгийн урамшууллыг олгосон. Газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, үйл ажиллагааны тайлан, объектын тайлан	Ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын үр дүнг үнэлэн урамшуулал олгосон байна.	Ажилчидтай 2021 оны 01 дүгээр сарын 04 ний өдөр хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан ба ажлын үр дүнг сар бүрийн тайлангийн биелэлт, ажлын гүйцэтгэлийг харгалзан үзэж үр чадварын 2.4 сая төгрөг, хоол унааны хөнгөлөлтөд 4.0 сая төгрөгийн нэмэгдлийг олгосон. Засгийн газрын 43 дугаар тогтоол гарсантай холбогдуулан төсвийн зардлын хэмнэлт хийн шагнал цалин болон үр дүнгийн урамшууллыг энэ жил олгохооргүй	100%

				болон бусад мэдээ тайланг гаргаж аймгийн холбогдох хэсгүүдэд хүргүүлэн ажиллалаа. Ур чадварын нэмэгдэлд 9215,1 мян төгрөг, 7436,8 мян төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 5948,5 мянган төгрөгийн хоол унааны хөнгөлөлт тус тус бодож олгосон.		байхаар шийдвэрлэсэн.	
2.6.2	Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулан батлуулж холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлэх.		Үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг хүргүүлэх.	Төлөвлөгөө, тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ТЗУХ-т цаг хугацаанд нь хүргүүлсэн.	Төлөвлөгөө, тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ТЗУХ-т цаг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Объект тус бүрээр бэлтгэсэн мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна. Эхний хагас жилийн тайланг Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлсэн.	100%

Тайланг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

Дархан-Уул аймгийн
Засаг дарга
(албан тушаал)

Тэмдэг

Тайлагнасан:

"Дархан хот байгуулалт
барилга захиалагчийн газар"
ОНӨААТҮГ-ын Дарга
(албан тушаал)

Тэмдэг

(гарын үсэг)

/Б.АЗЖАРГАЛ/

(огноо)

Төсвийн Шууд захирагч



(гарын үсэг)

/Д.БАТБАЯР/

(огноо)

2021/06/25

78